

**Эрүүл мэндийн газрын 2024 оны жилийн эцсийн Гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтэд хийсэн дотоодын хяналт-шинжилгээ, үнэлгээний дүн**

2024.12.12

Булган аймаг

Нэг. Хяналт-шинжилгээ, үнэлгээний зорилго

Эрүүл мэндийн газрын 2024 оны жилийн эцсийн Гүйцэтгэлийн төлөвлөгөө нь хэрэгжүүлэхээр төлөвлөсөн, хүлээгдэж буй үр дүнд хүрсэн эсэхийг нягтлах, арга хэмжээ тус бүрийн хүрсэн түвшинг тодорхойлох, шаардлагатай санал, зөвлөмжийг боловсруулах, шийдвэр гаргагч нарт холбогдох мэдээлэл өгөх зорилгоор хяналт шинжилгээг хийж гүйцэтгэсэн болно.

Хоёр. Хяналт-шинжилгээ үнэлгээний арга зүй

Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор батлагдсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт болон захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ын 4.4 дүгээр заалт, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын 2020 оны “Аргачлал, загвар батлах тухай” 100 дугаар тушаалын 7 дугаар хавсралтын дагуу тус газрын Удирдлага төлөвлөлт, санхүүгийн хэлтсийн ГТ-ний биелэлт хариуцсан мэргэжилтэн нь байгууллагын үйл ажиллагааны тайланг нэгтгэсэн болно. Журмын 6.2.1, 6.2.2 болон 6.7 дугаар заалтуудыг үндэслэн Хяналт-шинжилгээ, үнэлгээ, мэдээллийн хэлтэс нь Эрүүл мэндийн газрын 2024 оны жилийн эцсийн төлөвлөгөөний биелэлтэд хяналт-шинжилгээ, үнэлгээг гүйцэтгэсэн бөгөөд үнэлгээг бодлогын баримт бичгийн зорилт, арга хэмжээний хэрэгжилтийн хувийг тодорхойлох аргачлалаар тооцон гаргасан болно.

Гурав. Хяналт-шинжилгээ, үнэлгээний дүн

Эрүүл мэндийн газрын 2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд нийт 61 үйл ажиллагааг хэрэгжүүлэхээр төлөвлөсөн байна. Тайлант онд төлөвлөсөн арга хэмжээнүүдээс:

арга хэмжээ буюу нийт ажлын 82.0%-нь 100 хувийн хэрэгжилттэй;

арга хэмжээ буюу 16.4%-нь 90 хувийн хэрэгжилттэй;

1 арга хэмжээ буюу 1.6%-нь 70 хувийн хэрэгжилттэй;


ЭМГ-ын 2024 оны жилийн эцсийн гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлт түвшиндээ бүрэн хүрээгүй, тодорхой үр дүнд гарч эхэлж байгаа, хэрэгжилт, үр дүнг нэмэгдүүлэх шаардлагатай бол 70-100 хүртэл хувь) гэж үнэлэгдэв.

Хүснэгт 1 . Хяналт-шинжилгээний чанарын үзүүлэлт

Үнэлгээ	Арга хэмжээ	
	Тоо	Эзлэх хувь
100 хувь буюу “бүрэн хэрэгжсэн”		

90 хувь буюу “зорилт, арга хэмжээний хүрэх түвшинд бүрэн хүрээгүй боловч зохион байгуулалтын арга хэмжээ бүрэн авагдсан, холбогдох байгууллагын шийдвэр гарсан, гол үр дүн нь гарч эхэлж байгаа”		
70 хувь буюу “тавьсан зорилт, арга хэмжээнд хүрэх зорилгоор өөрсдөөс хамаарах шийдвэрийг гаргасан, санхүүгийн асуудал шийдвэрлэгдсэн, дээд шатны байгууллагад өргөн барьсан буюу гүйцэтгэл нь тодорхой хэмжээгээр гарч эхэлж байгаа”		
50 хувь буюу “тухайн зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэх бэлтгэл болон боловсруулалтын шатны ажил бүрэн хийгдсэн, ажил тодорхой хэмжээнд эхэлсэн”		
30 хувь буюу “тухайн зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэх бэлтгэл ажил хийгдэж дуусаад боловсруулалтын шатанд байгаа”		
0 хувь буюу “тухайн зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардлагатай тооцоо, судалгаа хийх, асуудал тодорхойлох зэрэг бэлтгэл хангахтай холбогдсон үйл ажиллагааг авч эхэлж байгаа эсвэл хэрэгжүүлэх талаар ямар нэгэн ажил зохион байгуулаагүй”		
Нийт		
Дундаж		.8 хувь


Эрүүл мэндийн газрын 2024 оны жилийн эцсийн Гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтийн эзлэх хувь



Хүснэгт 2. 2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилт (хариуцсан нэгжээр)

№	Хэлтэс	2024 онд төлөвлөсөн нийт арга хэмжээ	Төлөвлөгөөний хэрэгжилт, хувь				
	УТСХ						
	НЭМХ						
	ЭТҮХ						
	ХШҮМХ						
	ХХ						

Зураг 2. Эрүүл мэндийн газрын 2024 оны жилийн эцсийн гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтийн хувь (хариуцсан нэгжээр)



Дөрөв. Дүгнэлт

- ❖ Эрүүл мэндийн газрын 2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлт 97.8 хувийн хэрэгжилттэй "тодорхой үр дүнд хүрсэн" гэж үнэлэгдэж байгаа буюу зорилт нь шалгуур үзүүлэлт, зорилтот түвшиндээ бүрэн хүрээгүй, тодорхой үр дүн гарч эхэлж байгаа, хэрэгжилт, үр дүнг нэмэгдүүлэх шаардлагатай байна. Төлөвлөгөөнд 61 арга хэмжээ батлагдсанаас 50 арга хэмжээ буюу нийт ажлын 82.0%-нь 100 хувийн хэрэгжилттэй; 10 арга хэмжээ буюу 16.4%-нь 90 хувийн хэрэгжилттэй; 1 арга хэмжээ буюу 1.6%-нь 70 хувийн хэрэгжилттэй; 50 хувь, 30 хувь, 0 хувийн хэрэгжилттэй арга хэмжээ байхгүй байна.
  - Тавьсан зорилт, арга хэмжээнд хүрэх зорилгоор өөрсдөөс хамаарах шийдвэрийг гаргасан, санхүүгийн асуудал шийдвэрлэгдсэн, дээд шатны байгууллагад өргөн барьсан буюу гүйцэтгэл нь тодорхой хэмжээгээр гарч эхэлж байгаа 70.0 хувийн хэрэгжилттэй багийн эмч

нарыг мобайл тоног төхөөрөмжөөр үе шаттай хангах гэсэн арга хэмжээ байна.

- ❖ Тухайн жилийн төлөвлөлт тодорхой байх, мөн мэргэжилтнүүд арга хэмжээний тайланг хэт нуруу, 2000 тэмдэгтэд багтаагаагүй, оновчгүй, нотолгоонд суурилагагүй ирүүлсэн байсныг хянаж, дахин шаардлагын түвшинд тайланг гаргуулсан.

#### Тав. Зөвлөмж

1. Эрүүл мэндийн газрын 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг боловсруулахдаа Монгол Улсын таван жилийн үндсэн чиглэл, Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр, Монгол Улсын хөгжлийн бодлогын баримт бичгүүд болон аймгийн Засаг даргын мөрийн хөтөлбөр, Засаг даргын Эрүүл мэндийн сайдтай байгуулсан гэрээнд нийцүүлэн оновчтой зөв тодорхойлох, үндэслэж байгаа бодлогын баримт бичгийн заалтын дугаарыг бичиж тусгах

2. Дээрх бодлогын баримт бичиг, хөтөлбөрт тусгагдсан үйл ажиллагааг хэлтсийн төлөвлөгөө, төрийн албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгасан эсэхэд хэлтсийн дарга нар хяналт тавьж ажиллах

Арга хэмжээ төлөвлөхдөө шалгуур үзүүлэлтийг нотолгоонд суурилан зөв тодорхойлох

Гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтийг тайлагнахдаа оновчтой, шалгуур үзүүлэлтийн дагуу товч, тодорхой, 2000 тэмдэгтэд багтааж, үр дүнг тусгаж тайлагнаж хэвших шаардлагатай байна.

Эрүүл мэндийн газар  
Хяналт-шинжилгээ, үнэлгээ, мэдээллийн хэлтэс